БАТЛАВ:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....

А.ДАВААЖАРГАЛ

АТА12[illegible]6594204 9024070548

ЗАЛУУЧУУДАД ОЛОН УЛСАД ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨГДСӨН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ОЛГОЖ АЖЛЫН БАЙР САНАЛ БОЛГОХ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны ... сарын ..... -ний өдөр № ..... Улаанбаатар хот

1	Даалгавар боловсруулах хууль, эрх зүйн үндэслэл:	• “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Цахим монгол (иргэн, төр, хувийн хэвшлийн нэгдсэн систем) **Зорилт 5.3.** Хүний хөгжлийг дэмжсэн, үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ. • Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн **11.1.3.** гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх; **11.1.6.** мэргэжлийн ур чадвараа сайжруулах, шинэ мэргэжил эзэмших сургалтад ажилгүй залуучуудыг хамруулах; • Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.30-д 2025 оныг "Залуучуудын жил" болгон зарлаж, оюутан, залуучуудын чөлөөт цагаараа ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх эрх зүйн орчныг сайжруулж, нийгмийн идэвх, оролцоог дэмжинэ. Мөн 2.1.1.31. Залуучуудын боловсролын болон мэргэжлийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоог дэмжих "Залуусын оролцоо хөтөлбөр"-ийг хэрэгжүүлнэ.
2	Даалгавар боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлага:	Монгол улсад харилцаа холбоо, мэдээлэл, технологийн салбарт үйл ажиллагаа явуулж буй технологийн компани, стартапуудад тулгарч буй асуудлуудын нэг нь чадварлаг хүний нөөцийн дутагдал болоод байна. Мөн цахим шилжилт эрчимтэй өрнөж буй энэ цаг үед уламжлалт бизнесийн байгууллага, ажлын байранд ч цахим ур

Scanned with CamScanner

		чадварын хэрэгцээ улам нэмэгдэж байгаа төдийгүй холбогдох ур чадвар суулгахад чиглэсэн хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарахыг олон улсын байгууллагууд зөвлөж байна. Мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх дотоодын төдийгүй олон улсын стандартад нийцсэн сургалтууд сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь сайшаалтай боловч салбарын хүний нөөцийг олон улсын түвшинд бэлтгэх хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага хэвээр байна. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023 оны 08 дугаар сард АНУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэрх Google компанитай хийсэн стратегийн хамтын ажиллагааны хүрээнд цахим шилжилтийг дэмжих 1000 боловсон хүчнийг Google компанийн арга зүйгээр сургаж, тухайлбал дэлхийн 80 гаруй оронд хэрэгждэг Grow with Google хөтөлбөрт хамруулан сертификатжуулах замаар Монгол Улсын цахим шилжилтийг дэмжихээр тогтсон.
3	Зорилго:	• Grow with Google нь Монгол Улсад мэдээллийн технологийн салбарт дутагдаж буй хүний нөөцийн эрэлтийг хангах 650 боловсон хүчнийг Google компанийн тодорхойлсон 6 төрлийн сертификатыг олгох хөтөлбөрийг боловсруулан цахим, танхим хосолсон хэлбэрээр бэлтгэн, хөтөлбөрийг хэрэгжүүлэх; • Цахимд шилжиж буй аж ахуйн нэгжүүдэд цахим ур чадвартай боловсон хүчин санал болгох; • Google компанийн албан ёсны эрхтэйгээр хэрэгжих “Google Career Certificates” тэтгэлэгт хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын цахим шилжилт, мэдээлэл, технологийн салбарын хөгжлийг дэмжих, тус салбарт ажиллаж буй манлайлагчдыг чадавхжуулах, дутагдаж буй хүний нөөцийг шинээр бүрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэргэжлийн ур чадварыг оролцогчдод эзэмшүүлж, олон улсын түвшинд бэлтгэгдсэн өндөр ур чадвартай, мэргэжлийн боловсон хүчнийг хөдөлмөрийн зах зээлд бэлтгэж нийлүүлэх юм.
4	Хамрах хүрээ, агуулга:	• Төгсөх курсийн оюутнууд; • Зорилтот бүлгийн залуус; • Мэргэжлийн ур чадвараа сайжруулах хүсэлтэй залуус;

Scanned with CamScanner

		• Жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнес эрхлэх сонирхолтой залуус.
5	Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв болон Google company-ийн хамтын санхүүжилттэй.
6	Төслийн хэрэгжүүлэх дэлгэрэнгүй ажлын даалгавар /Хэрэгжүүлэх төлөвлөгөө/:	**Даалгавар 1:** Залуучуудын цахим ур чадварыг дэмжих зорилгоор Олон улсын цахим эдийн засаг, цахим шилжилт, цахим ур чадварыг хөгжүүлэхтэй холбоотой сайн туршлагыг судалж, залуучуудад зориулсан дижитал ур чадвар шаардсан ажлын байрыг тодорхойлох, Ойрын 5 жилд эрэлттэй байх дижитал ажлын байрыг Монгол улсын түвшинд тодорхойлох, Дэлхийн 80 гаруй оронд хэрэгждэг 2,400,000 төгсөгчтэй Grow with Google хөтөлбөрийг Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд болон дотоодын хүний нөөцийн ур чадварын хэрэгцээ шаардлагатай уялдуулан хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах,оролцогчдын сонгон шалгаруулалтыг зохион байгуулах; **Даалгавар 2:** Оролцогчдод зориулсан хөтөлбөрийн удирдамж, оролцогчийн гарын авлага бэлтгэх, шаардлагатай бусад материалыг боловсруулах сургалтын зохион байгуулалтыг удирдан чиглүүлэх, хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах, оролцогчдыг идэвхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; **Даалгавар 3:** Хөтөлбөрт шаардлагатай merchandise худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулах, хөтөлбөрийн үр дүнг тайлагнах; **Даалгавар 4:** Ажил олгогч аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагаа үүсгэх, идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, шинэ ажлын байр эрэлхийлж буй оролцогчдыг ажлын байрны саналд холбох, жижиг, дунд болон гарааны бизнес эрхлэгчдийг бизнесээ сайжруулах төслийн санал боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.
7	Үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага:	• Google компанийн албан ёсны зөвшөөрөлтэйгөөр Google Career Certificate тэтгэлэгтэй хөтөлбөрийг цахим, танхим хосолсон хэлбэрээр хэрэгжүүлэх чадамжтай байх • Удирдан зохион байгуулах багийн гишүүд Google Career Certificate авсан байх. • Цахим ур чадвар эзэмшүүлэх сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан туршлагатай байх,

Scanned with CamScanner

		• Олон улсад Grow with Google төслийг хэрэгжүүлсэн туршлагатай
8	Бусад шаардлага:	• Цахим шилжилтийг дэмжих чиглэлээр төр, Олон улсын байгууллагад ажил үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай байх;
9	Ажлаа тайлагнах:	**ЭХНИЙ ТАЙЛАН:** • Залуучуудын ажлын байр, хүний нөөцийн судалгаа боловсруулах; • Grow with Google хөтөлбөрийн сургалтын агуулгыг дотоодын хүний нөөцийн шаардлагатай уялдуулан шинэчлэн боловсруулсан байх; • Хөтөлбөрийн сургалтын нарийвчилсан төлөвлөгөө, удирдамж, сургалтын гарын авлага боловсруулсан байх; • Оролцогчдын сонгон шалгаруулалтын бэлтгэл, сонгон шалгаруулалтын багийн төлөвлөгөө, үр дүн бэлтгэх; • Хөтөлбөрийн сургалтын merchandise; • Оролцогчдыг идэвхжүүлэх, хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд таниулах маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулах; • Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах. **ДУНД ХУГАЦААНЫ ТАЙЛАН:** • 2025 оны 3 дугаар сарын буюу эхний элсэлтийн үр дүнгийн тайлан боловсруулах; • Эхний элсэлтийн амжилттай хэрэгжсэн туршлага, сайжруулалт, зөвлөмж боловсруулах; • 2 дахь элсэлтийн хөтөлбөрийн сургалтын нарийвчилсан төлөвлөгөө, удирдамж, сургалтын гарын авлага боловсруулах; • 2 дахь элсэлтийн оролцогчдын сонгон шалгаруулалтын бэлтгэл, сонгон шалгаруулалтын багийн төлөвлөгөө, үр дүн бэлтгэх; • 2 дахь элсэлтийн оролцогчдыг идэвхжүүлэх, хөтөлбөрийн ач холбогдлыг олон нийтэд таниулах маркетингийн стратеги төлөвлөгөө боловсруулах;

Scanned with CamScanner

		• 2 дахь элсэлт дээр хамтран ажиллах ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулах. **ЭЦСИЙН ТАЙЛАН:** • Хөтөлбөрийн үр дүн, сайжруулалт, зөвлөмж боловсруулах; • Оролцогчдын ажлын байрны санал авсан үр дүнгийн тайлан боловсруулах; • Ажил олгогч аж ахуйн нэгж байгууллагуудын хамтын ажиллагааны үр дүнг тайлагнах.
10	Хэрэгжих хугацаа:	Хөтөлбөрийг 2 үе шаттай хэрэгжүүлнэ. Үүнд: • Эхний 350 элсэгчдийг 2025 оны 03 дугаар сард зохион байгуулна. • Сургалт 2025 оны 3 дугаар сараас эхлэн 6 дугаар сард дуусна. • 2025 оны 6 дугаар сард дадлага эсвэл ажлын байр санал болгоно. • Үйлчилгээний гүйцэтгэгч нь Захиалагчтай гэрээ байгуулж, үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж 2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дуусгана. • Захиалагч болон үйлчилгээний гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу Ажлын даалгаварт туссан ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгснөөр гэрээг дүгнэн акт үйлдэнэ.
11	Хамтран ажиллах байгууллага:	• Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам • Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам • Боловсролын яам
12	Хяналт, шалгалт	• Захиалагчаас ажлын явцад хяналт тавьж, гүйцэтгэлийг хянан баталгаажуулна.
13	Хүлээгдэж буй үр дүн:	• Хөтөлбөрийн зорилтот бүлгийн оролцогчид бодит үр дүн гаргасан байх;

Scanned with CamScanner

		• Grow with Google сертификаттай төгсөгчдийн тоо 80%-аас доошгүй байна; • Шинэ ажлын байр эрэлхийлж байгаа их сургууль төгсөх курсийн оюутнууд, зорилтот бүлгийн, мэргэжлээ өөрчлөх хүсэлтэй залуусын 70%-аас доошгүй оролцогчид ажлын эсхүл дадлага ажлын санал авах; • Жижиг, дунд үйлдвэрлэл, гарааны бизнес эрхлэх сонирхолтой эсхүл эрхэлж буй оролцогчдын 50% аас доошгүй хувь нь шинэ бизнесийн эсхүл эрхэлж буй бизнесээ сайжруулах төсөл боловсруулсан байх; • Ажлын байранд бэлтгэх зөөлөн ур чадварын сургалтыг 10-аас доошгүй удаа ажил олгогч байгууллагууд, болон зочин илтгэгчидтэй хамтран зохион байгуулна.

ТАНИЛЦСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ГАЗРЫН ДАРГА Ч.ЭНХ-АМГАЛАН

ХЯНАСАН:

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ

ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА Г.БАТДОРЖ

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН

ГАЗРЫН ДАРГА Ж.ОТГОНБАТ

НЭГДСЭН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН

ХЭЛТСИЙН ДАРГА Д.МӨНХЦЭЦЭГ

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ӨНӨРХУЯГ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОЛОН УЛСЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ,

ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, ТУСГАЙ САНГИЙН БОДЛОГО,

ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ Ш.ДЭЛГЭРМАА

Scanned with CamScanner